

Бүхий л хичээл зүтгэлээр ажилла

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг

Бид ажил үүрэгтээ Их Эзэнээс суралцах ёстой. Ингээд дараа нь залхууралгүйгээр бүхий л хичээл зүтгэлээр ажиллах ёстой.

Ах нар аа, та нартай хамт байгаадаа би талархаж байна. Та нарын итгэлтэй санваарын үйлчлэлийн тухай мэддэг зүйлдээ миний бие энд даруусгагдан зогсож байна. Би өнөө орой энэ үед та нарт Их Эзэний үйлчлэлд хичээл зүтгэлээ дайчлан ажиллах талаар ярья. Саяхан надад тохиолдсон зүйлс энэ сонголтыг хийхэд хүргэсэн билээ.

Үүний нэг нь, Аароны санваартнуудад зориулсан гайхалтай шинэ товхимлыг анхааралтай судалсан явдал байлаа. *Бурханы өмнө хүлээх үүрэг* нэртэй энэ товхимлын тухай Давид Л.Бек ах ярьсан. Би энэхүү номноос залуу эрэгтэйчүүдээс юу шаарддаг, тэд хэн болохыг хүсдэг тухай уншиж тунгаан бодох зуураа насан туршдаа хичээн зүтгэсэн нэгэн санваартанд Ерөнхийлөгч Бригам Янг юу гэж амласныг энэ товхимолд хэрхэн тайлбарласныг ойлгосон юм:

“Дуудлагаа итгэлтэйгээр гүйцэтгэдэг, Бурхан түүнээс шаардсан зүйлүүдийг үргэлж хийхдээ баяртай байдаг, амьдралынхаа туршид үүрэг хариуцлага бүрээ байнга биелүүлдэг санваартан хүн Бурханы оюун ухааныг байнга мэддэг байхын тулд Бурханы зүйлүүдийг хүлээж авах онцгой боломжийг төдийгүй, мөн хэрхэн хүлээн авах мэдлэгтэй болно.”¹

Хэдхэн долоо хоногийн өмнө би нэг шинэ диконыг хичээл зүтгэлийн замаа эхлэхийг нь харсан юм. Аав нь хүүгийнхээ гаргасан схемийг надад үзүүлсэн юм. Схемд цуглааны танхимын эгнээ бүрийг харуулсан байсан бөгөөд, дикон бүрээс ариун ёслолыг түгээхэд оролцох тоо, мөн гишүүдэд ариун ёслолыг түгээхээр танхим дундуур тэдний явах замыг хүртэл зурж гаргасан байв. Тэр хүү, хэнээр ч хэлүүлэлгүйгээр, санваарын үйлчлэлээ амжилттай байлгахын тулд төлөвлөгөө гаргасныг үзээд хүүгийн аав бид хоёр инээмсэглэж суусан юм.

Бурханы өмнө хүлээсэн үүрэг гэдэг тэр шинэ товхимол дахь загварыг би түүний хичээл зүтгэлээс олж харсан юм. Энэ нь, Их Эзэн өөрөөс чинь хүсэн хүлээдэг зүйлийг олж мэдээд, түүнийг биелүүлэх төлөвлөгөө хийж, төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд хичээл зүтгэл гарган ажиллаж, туршлага тань таныг хэрхэн

өөрчилж, бусдыг хэрхэн адисалсан тухай бусадтай хуваалцах явдал мөн.

Тэр дикон, Их Эзэн түүгээр өөрөөр нь хийлгэхийг хүсч дуудсан зүйлийг амжилттай биелүүлэхийн тулд уг схемийг гаргасан байлаа. Түүний санваарын үйлчлэлийн эхэнд, “Бурханы түүнээс шаардсан зүйлийг”² үргэлжлүүлэн хийхдээ баяртай байхыг Их Эзэн түүнд заасан байлаа.

Хичээл зүтгэлийн талаар ярихад хүргэсэн өөр нэг тохиолдол нь, энэ амьдрал дахь санваарын үйлчлэлээ дуусгах дөхөж буй нэг хүнтэй уулзаж ярилцсан явдал юм. Тэр хоёр удаа бишпоор үйлчилж байв. Намайг түүнтэй танилцахаас олон жилийн өмнө залуу байхдаа тэр анх бишпоор дуудагдсан ажээ. Одоо, тэр нас өндөр болж, бишпоосоо хоёр дахь удаагаа чөлөөлөгдөөд байна. Бие нь улам муудсаар байгаа учир санваартны аль нэг үйлчлэл түүнд хэцүү болсон байлаа.

Гэсэн ч, хичээл зүтгэлээ дайчлан ажиллах төлөвлөгөө түүнд байлаа. Сүмдээ явах чадалтай хэвээр байгаа гэнэ. Бүтэн сайн өдөр бүр ариун ёслолын цуглаанд ихэнх хүмүүсийн орж ирдэг хаалганд хамгийн ойрхон суудаг байлаа. Суудлаа эртхэн эзлэхийн тулд сүмд эртлэн очдог байж. Ирж байгаа хүн болгон, түүнийг бишоп байхдаа индэр дээр суугаад хардаг байсны адил, өөрсдийг нь тавтай морилохыг урьдаг хайрын харцыг хардаг байжээ. Үйлчлэлд зориулсан түүний хүч чармайлтын үнэ цэнийг бид мэддэг байсан учраас түүний нөлөө бидний сэтгэл санааг өргөж, бүлээцүүлдэг байж билээ. Түүний бишопын үүрэг дууссан ч санваарын үйлчлэл нь дуусаагүй байлаа.

Санваарын ийм агуу үйлчлэгчдийн олон жишээг та нар харсан. Би тэдний талаар мэдсэн зүйлээ өнөө орой та нарт ярихыг хичээе. Энэхүү хичээл зүтгэл нь тэд хэнд, ямар зорилгоор үйлчилж байгаагаа мэдэхээс эхэлдэг. Үүнийг зүрх сэтгэлдээ шингэтэл мэддэг болсноор энэ нь бүх зүйлийг өөрчлөх болно.

Би юуны өмнө Аароны санваартан залуу эрэгтэйчүүдэд хандан ярья. Өөрсдөдөө итгэмжлэн даатгасан Бурханы итгэл найдварын хэр хэмжээг мэдрэх тусам та нар илүү хичээл зүтгэл гаргаж ажиллах болно. *Бурханы өмнө хүлээсэн үүрэг* товхимолд та бүхэнд хандсан Тэргүүн Зөвлөлийн захиас байдаг.

“Тэнгэрлэг Эцэг та нарт ихээр найдан, итгэдэг бөгөөд та нарын хэрэгжүүлэх ёстой чухал зорилго Түүнд бий. Түүнд залбирлаар хандах юм бол Тэр та нарт туслах болно. Сүнсний өдөөлтийг сонс. Зарлигуудыг сахиж, хийсэн гэрээнүүдээ сахь.”³

Та нарын эзэмшдэг санваарыг сэргээхээр Иохан Баптист дэлхийд эргэж ирсэн юм. Тэр Аароны санваарын түлхүүрийг эзэмшдэг байв. Есүс баптисм хийлгэхээр

хандсан хүн нь Иохан байлаа. Түүнийг хэн дуудсаныг Иохан мэдэж байсан. Тэр Их Эзэнд хандан, “Би Танаар баптисм хүртэх учиртай”⁴ гэжээ.

1829 оны 5-р сарын 15-нд⁵ Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг томилохоор Их Эзэн өөрийг нь илгээхэд, Аароны санваар нь “тэнгэр элчүүдийн тохинууллын, наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүдийг атгадаг” гэдгийг Иохан мэдэж байлаа. Өөрийг нь хэн дуудсаныг мөн ямар агуу зорилгын тулд илгээгдсэнээ тэрээр мэдэж байв.

Та нарын санваар, өнөөдөр Түүний Сүмийн гишүүдэд Их Эзэний Зоогийн ариун ёслолыг түгээх боломжийг олгодог юм. Энэ нь, Аврагч мөнх бус байдлын үйлчлэлийнхээ үед Арванхоёрт олгосон тэрхүү онцгой боломж билээ. Тэрээр Амилсныхаа дараа Өөрийнх нь Сүмийг удирдах арванхоёр шавийг дуудахдаа энэхүү онцгой боломжийг тэдэнд дахин өгсөн билээ.

Мормоны Номонд дүрсэлснээр, Их Эзэн Өөрийн хязааргүй хэмжээлшгүй золиослолын бэлгэдлийг өөрөө бэлтгэн, хүмүүст түгээсэн билээ. Санваарын үйлчлэлээ гүйцэтгэхдээ Түүний тухай мөн Тэрээр та нарыг хэрхэн хүндэтгэдгийг бодогтун. Та нар Түүнийг санаснаар, бүх чадлаараа Түүний адил итгэлтэйгээр, хамгийн сайнаар тэрхүү ариун үйлчлэлийг гүйцэтгэх шийдвэр төгс байх болно.⁶ Энэ нь Их Эзэн та нарыг бэлтгэж байгаа мөн Түүний та нарыг дуудах санваарын үйлчлэл болгонд хичээл зүтгэл гаргах хүч чадлыг тань нэмэгдүүлэх амьдралын чинь дадал зуршил болж чадна. Тэрхүү шийдвэр төгс байдал нь, эрт дээр үед “Бурханы Хүүгийн жаягаар Ариун Санваар”⁷ гэж нэрлэгддэг байсан Мелкизедек санваарыг хүлээн авахад тань бэлтгэхэд та нарт туслах болно.

Одоо би Мелкизедек санваарт үйлчлэхээр хүндэтгэл хүлээн дуудагдсан хүмүүст хандан ярихыг хүсч байна. Аароны санваарын адил, Мелкизедек санваар нь Их Эзэний хийх ёстой зүйлийг хийхээр хүлээлгэсэн итгэл найдвараас илүү зүйл юм. Энэ бол Түүнтэй адил болох урилга юм. Тэрбээр ийнхүү амласан юм:

“Учир нь миний ярьсан энэхүү хоёр санваарыг хүртэхэд, мөн дуудлагаа эрхэмлэн биелүүлэхэд итгэлтэй байдаг хэн ч гэсэн, биеэ шинэчлэхийн тулд Сүнсээр ариусгагддаг бөлгөө.

“Тэд Мосегийн хийгээд Аароны хөвгүүд мөн Абрахамын удам, мөн сүм ба хаант улс, мөн Бурханы сонгосон хүмүүс болдог.

“Мөн тэрчлэн энэхүү санваарыг хүлээн авдаг тэд бүгд намайг хүлээн авдаг хэмээн

Их Эзэн хэлдэг;

“Учир нь миний үйлчлэгчдийг хүлээн авдаг тэрээр намайг хүлээн авдаг болой;

“Мөн намайг хүлээн авдаг тэрээр Эцэгийг маань хүлээн авдаг болой;

“Мөн Эцэгийг маань хүлээн авдаг тэрээр Эцэгийн маань хаант улсыг хүлээн авдаг; тиймийн тул Эцэгт минь байгаа бүхэн түүнд өгөгдөх болно.”⁸

Бүх л санваарын атгагчдад энэхүү агуу адислалд хүртлээ өргөмжлөгддөг хэв загвар байдаг. Их Эзэний бидэнд зориулан гаргасан хэв загварыг харуулдаг судрын нэг хэсэг нь Сургаал ба Гэрээний 107 дахь хэсэгт байдаг:

“Иймийн тул, эдүгээ хүн бүр өөрийн үүргийг мэдэж аваг, тэрээр томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг.

“Залхуу хойрго тэрээр зохистойд үл тооцогдох бөлгөө, мөн үүргээ сурдаггүй мөн өөрийгөө нотлон харуулдаггүй тэрээр зохистойд үл тооцогдох ёстой. Бүр тийм буюу. Амен.”⁹

Бид Их Эзэнээс үүргийнхээ талаар суралцаж, тэгээд хэзээ ч залхуу мөн хойрго байлгүйгээр, бүх хүч чадлаараа ажиллах ёстой. Энэ загвар нь энгийн боловч дагахад амархан биш. Бидний анхаарал маш амархан сарнидаг. Өдөр тутмын мэдээг судлах нь санваартны гарын авлагыг уншихаас илүү сонирхолтой санагдаж болох юм. Амрахаар суух нь, бидний санваарын үйлчлэл хэрэгтэй байгаа хүмүүстэй очиж уулзах цаг тохирохоос илүү аятайхан санагдаж болох юм. Бусад сонирхлоосоо эсвэл ядарснаас болоод амрахсан гэж бодогдсон үед санваарын үүргээсээ хөндийрсөн үед би Түүнийг сана” хэмээн өөрийгөө уриалан дууддаг. Их Эзэн бол санваарын үйлчлэлд хичээл зүтгэлийн төгс төгөлдөр жишээ билээ. Тэр бол бидний ахмад. Тэрээр биднийг дуудсан. Тэр бидний өмнө явдаг. Өөрийг нь дагаж, бусдыг өөрсөдтэй хамт авчир хэмээн Тэр биднийг сонгосон билээ.

Энэ үдэш би Түүнийг санаж, зүрх сэтгэл догдлон хөдөлж байна. Энэ үдэш бол, Түүний амилалтыг дурсан санадаг Христийн амилалтын баярын ням гарагийн өмнөх орой юм. Амилалтын өмнөх өдрүүд дэх Түүний үлгэр жишээг би санаж байна.

Эцэгээ болон биднийг хайрладаг хайрынхаа улмаас Тэрээр мөнх бус хүмүүний амсаж чадахаас хамаагүй илүүгээр зовон шаналахыг хүлцэн тэвчсэн билээ. Тэрхүү хэмжээлшгүй золиослол Түүнээс юуг шаардсаныг Тэрбээр бидэнд ийн өгүүлсэн юм. Түүний дараах үгсийг та нар санаж байгаа:

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;

“Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд зовох ёстой;

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь мөн намайг тэрхүү гашуун аяганаас уухгүй, мөн айснаас эргэн буцахад хүргэж болохоор байсан билээ.

“Тэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг дуусгасан билээ.”¹⁰

Калвари дээрх загалмайнаас, Аврагч “Гүйцэлдлээ”¹⁰ хэмээн зарласан юм. Тэгээд Түүний Сүнс, биеийг нь орхиж, мөнх бус цогцсыг нь булшинд эвтэйхэн тавьсан юм. Тэрээр амилалтынхаа өмнө, гурван хоногийн дотор сүнсний дэлхийд хийсэн зүйлээрээ бидэнд нэгэн сургамжийг өгсөн юм. Түүний төлөө үйлчлэлд би яггүй хүнд ажлаа амжуулчихлаа, одоо амарч болно шүү дээ гэж бодоход уруу татагдсан үедээ Түүний Амилалтыг санадаг юм.

Аврагчийн үлгэр жишээ надад урагш давших зоригийг өгдөг. Түүний мөнх бус амьдрал дахь хөдөлмөр гүйцэлдсэн ч, Тэрээр сүнснүүдийг аврах агуу ажлаа үргэлжлүүлэх шийдвэр төгс бодолтойгоор сүнсний дэлхийд очсон юм. Цагаатгагч золиослолоор нь дамжин боломжтой болсон нигүүлслийг хүлээн авах боломжтой хүмүүсийг аврахын тулд Тэрээр итгэлтэй сүнснүүдийн ажлыг зохион байгуулсан юм. Сургаал ба Гэрээний 138-р хэсэг дэх үгсийг санацгаая:

“Гэвч болгоогтун, зөв шударгыг үйлдэгчдийн дундаас тэрбээр өөрийн хүчийг зохион байгуулж, мөн элч нарыг томилон хүч чадал хийгээд эрх мэдлээр хувцаслаж, мөн урагш одон харанхуйд байсан тэдэнд, бүр хүмүүний бүх сүнснүүдэд сайн мэдээний гэрлийг хүргэн, мөн итгэмжлэлийг тэдэнд олгодог байв; мөн тийн сайн мэдээ нь нас барагседад номлогддог байлаа.

“Мөн сонгогдсон элч нар Их Эзэний хувьд хүлээн зөвшөөрч болохуйц өдрийг зарлан тунхаглах, мөн хүлээсэнд байсан боолчлогдогсод, бүр нүглүүдээсээ наманчилж мөн сайн мэдээг хүлээн авч болох тэд бүгдэд эрх чөлөөг тунхаглахаар урагш оддог байв.”¹²

Бид Түүнийг санах болгонд, санваартны хөдөлмөрөөс амрахыг хүсэх уруу таталтыг сөрөн зогсох нь илүү амархан болдог. Бид Түүнийг өнөөдөр дурсан санаж байна. Учир нь бид үүрэгтээ суралцахаар, хийсэн гэрээнүүдээ бүхий л хичээл зүтгэлээр

сахих шийдвэр төгс байдлаар жигүүрлэн энд ирээд байгаа билээ. Түүний үлгэр жишээнээс суралцаж, бидэнд энэ амьдралд Түүний өгөх үүрэг даалгавруудыг эцсээ хүртэл тэвчин биелүүлж Эцэгийнхээ хүслийг Тэрээр хэрхэн биелүүлдэг байсан болон биелүүлдгийн адилаар бид мөн Түүний хүслийг тийнхүү биелүүлэх шийдвэр төгс байх болно.

Энэ бол Их Эзэний Сүм. Тэр бидний дутагдлыг мэддэг байсан ч бидэнд итгэл найдвар хүлээлгэн, биднийг дуудсан юм. Тэр бидэнд тулгарах саад бэрхшээлийг мэдэж байсан. Итгэлтэй үйлчлэл болон Түүний Цагаатгалаар дамжуулан бид Түүний хүсдэг зүйлийг хүсч, мөн Түүний өмнөөс өөрсдийн үйлчилдэг хүмүүсийг адисалж чадна. Бид Түүнд өнө удаан, хичээл зүтгэлээр үйлчилснээр өөрсдөө өөрчлөгдөх болно. Бид Түүнтэй илүү адилхан болно.

Түүнд үйлчлэгчдийн амьдрал дахь гайхамшгийн баталгааг би харсан хүн. Би үүнийг хэдхэн долоо хоногийн өмнө, итгэлтэй нэгэн санваартны зочны өрөөнд харсан юм.

Би түүнийг дикон байхад нь, эцэг, бишоп, гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн байхад нь мэддэг байсан. Би түүнийг Бурханы хүүхдүүдэд санваараараа, хичээл зүтгэлээрээ үйлчилснийг нь олон арван жилийн турш харсан хүн.

Гэрийнхэн нь түүнийг тойроод зочны өрөөндөө цугларсан байв. Костюм, цагаан цамц өмсч, зангиа зүүсэн тэрээр инээмсэглэж байлаа. Түүнд эмчилгээ хийж байгаа ч эдгэрэхгүй байгаа гэж надад хэлсний улмаас би тэнд очсон болохоор түүний цэмцгэр байдал миний гайхлыг төрүүлж билээ.

Тэрээр санваарын үйлчлэлээр насан туршдаа үйчлэхдээ зуу зуун зочдыг хүлээн авдаг байсан шигээ л надтай мэндлэв. Тулгарсан бэрхшээлд нь туслахаар би ирсэн ч, санваарын үйлчлэлд олонтоо тохиолдогоор, би өөрөө туслуулж, өөрөө суралцсан.

Бид суугаад яриа хөөрөө өрнүүлсэн нь сэтгэлд нэг л сайхан байлаа. Ээж минь хэзээ хэзээгүй өөд болох нь ойртсон үед аав нь ээжид минь яаж тусалж байсан тухай тэр надад ярилаа. Би тэр талаар огт мэдээгүй байсан юм. Хүнийг хэрхэн халамжлахыг тэр ааваасаа хөвгүүн байхдаа сурсан гэнэ. Үүнийг би тэр үед мэдсэн. Би санваарын үйлчлэл үзүүлэх, хэн нэгэнд туслахаар эсвэл адислал өгөхөөр явахдаа хөвгүүдээ дагуулж явдаг байсандаа баярлаж билээ.

Хэдхэн минутын дараа, тэрээр, “Таныг надад адислал өгөөч гэж гуйж болох уу?” хэмээн намуухан дуугаар асуув. Түүнтэй олон жилийн турш хамт үйлчилсэн,

гадасны хуучин ерөнхийлөгч нь, Мелкизедек санваарын хүчээр ариулсан тосыг тэргүүн дээр дусаав.

Би уг адислалыг амлалтаар лацдах зуураа, Их Эзэний энэхүү итгэлтэй санваартны төлөө хийсэн зүйлсийн заримыг би Ариун Сүнсээр заалгасан юм. Тэр цэвэр ариун, нүгэл нь угаагдсан байлаа. Аврагчийн хүсдэг зүйлийг хүсэхээр түүний байдал өөрчлөгдсөн байв. Тэр үхлээс огт айхгүй байлаа. Зүрх сэтгэлийнх нь чинхүү хүсэл бол гэр бүлдээ болон өөрт нь хэрэгтэй Тэнгэрлэг Эцэгийн бусад хүүхдүүдэд үйлчлэхийн төлөө амьд явах явдал байлаа.

Их Эзэн Өөрийн гандан бууршгүй хичээл зүтгэлтэй санваартан үйлчлэгчдэд нинжин сэтгэлээр ханддагийг гэрчилсэндээ би баярлан тэр шөнө тэднийхээс гарч билээ. Тэрээр Өөрийнх нь хүсдэг зүйлийг үйлчлэгчид нь хүсдэг байхын төлөө, Өөрийнх нь хийдгийг тэд хийдэг байхын төлөө тэдний зүрх сэтгэлийг өөрчилдөг юм.

Би одоо Их Эзэний санваартан үйлчлэгчдэд хандан энэ зөвлөгөөг өгснөөр үгээ өндөрлөө. Судрууд болон амьд бошиглогчдын үгсээс гүн гүнзгийгээр, хичээнгүйлэн суралцагтун. Бурхан Эцэг болон Түүний Хайртай Хүүгийн үнэн бодит байдлыг та нарт илчлэх Ариун Сүнсний төлөө цөхрөлтгүй шаргуу залбирцгаа. Өөрөөс чинь юу хүсч байгааг Их Эзэн харуулахын төлөө Сүнснээс гуй. Түүнээс мэдсэн зүйлээ хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга. Түүнийг дагах болно гэдгээ амла. Их Эзэний хүссэн зүйлийг хэрэгжүүлэхдээ шийдвэр төгс бай. Үйлчлэх боломжтой байсандаа талархан, дараа нь юу хийж болохыг мэдэхийн төлөө залбир. Бидний Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр амьд гэдгийг би гэрчилж байна. Тэд бидэнд хайртай мөн биднийг харж хандаж байдаг амилсан агуу Хүмүүн биес мөн. Санваарын түлхүүрүүд тэнгэрлэг элчүүдээр дамжин Бошиглогч Иосеф Смитэд сэргээгдсэн билээ. Тэдгээр түлхүүрүүд тасалдалгүйгээр Ерөнхийлөгч Томас С.Монсонд дамжин ирсэн билээ. Тэдгээр түлхүүрийг амьд Төлөөлөгч бүр эзэмшдэг.

Та нар Их Эзэний үнэн Сүмд томилогдсон санваарын үйлчлэгчдийн хувьд хүлээн авсан найдвар болон амлалтуудынхаа ач холбогдлыг Сүнсээр дамжуулан мэдрэх адислалыг би та нарт Есүс Христийн ариун нэрээр үлдээж байна, амен.

ЭШЛЭЛ

1. Teachings of Presidents of the Church: Brigham Young (1997), 128..
2. Teachings: Brigham Young, 128.
3. Fulfilling My Duty to God: For Aaronic Priesthood Holders (booklet, 2010), 5.
4. Матай 3:14.
5. Сургаал ба Гэрээ 13-ыг үз.
6. 3 Нифай 20:3-9-ийг үз.
7. Сургаал ба Гэрээ 107:3; мөн Алма 13:1-9-ийг үз.
8. Сургаал ба Гэрээ 84:33-38.
9. Сургаал ба Гэрээ 107:99-100.
10. Сургаал ба Гэрээ 19:16-19.
11. Иохан 19:30.
12. Сургаал ба Гэрээ 138:30-31.